



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 05 -ны өдөр

Дугаар A/12

Эрдэнэт

Бэлгийн замаар дамжих халдвартын эрт илрүүлэг  
үзлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16.5.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоол “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийн 3.5.2.2, ЭМС-ын А/327 тушаал, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 15/03 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын А/536 захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Бэлгийн замаар дамжих халдвартын эрт илрүүлэг үзлэг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай 12.000.000 /Арван хоёр сая/ төгрөгийг нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтийг хангаж тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын  
2020 оны 10. дугаар сарын 02-ны өдрийн  
10/10 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРЫН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

### Нэг. Үндэслэл

Монгол улсын хэмжээнд 2019 онд нийт 45232 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэнээс бэлгийн замаар дамжих халдварьн тохиолдол 17 865 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 39,4 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1735 буюу 10,8 хувиар өссөн байна. Бэлгийн замаар дамжих халдварт өвчний 32.3 хувийг заг хүйтэн, 39.7 хувийг тэмбүү, 27.9 хувийг трихомониаз, 0.1 хувийг ХДХВ/ДОХ тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тэмбүүгийн өвчлөл 932 тохиолдоор өссөн байна.

Орхон аймагт 2019 оны байдлаар 16 төрлийн цочмог халдварт өвчний тохиолдол 991 бүртгэгдсэнээс бэлгийн замаар дамжих халдвар 30,4 хувийг эзэлж өмнөх оноос 8,1 хувиар буурсан ба халдварт өвчлөлийн 54,8 хувийг тэмбүү, 14,6 хувийг заг хүйтэн, 38,9 хувийг трихомониазын халдвар тус тус эзэлж байна. Тэмбүүгийн халдвар авсан иргэдээс ажилгүй иргэд 69 (41,8%)-ийг эзэлж байна. Бэлгийн замаар дамжих халдварьн нийт тохиолдлын 75,7 хувийг дунд боловсролтой хүмүүс эзэлж, 16-29 насны залуучууд 70 хувийг эзэлж байна. Мөн 2019 онд төрөлхийн тэмбүү 5 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 3 тохиолдоор нэмэгдсэн байна.

### Хоёр. Зорилго

Зорилтот бүлгийн хүн амын дунд бэлгийн замаар дамжих халдварьн эрт илрүүлэг шинжилгээ, үзлэг оношилгоог зохион байгуулж, өвчлөл илэрсэн хүн амыг эмчлэх, диспансерийн идэвхтэй хяналтад авах, цаашид эрүүл аюулгүй зан үйл төлөвшүүлж эрсдэлт хүчин зүйлийг бууруулах

### Гурав. Хэрэгжүүлэгч байгууллага

Эрүүл мэндийн газар

### Дөрөв. Хамтран ажиллах байгууллага

Аймгийн Засаг даргын тамгын газар, Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын, Жаргалант сумын Засаг даргын тамгын газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Сум Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд

### Тав. Хамрагдах зорилтот бүлэг

Хөдөлгөөнт ажил эрхлэгчид (уул уурхайн салбарын ажилчид, алсын тээврийн жолоочид) хувиараа хөдөлмөр эрхэлж буй үсчин, оёдолчин, тогооч, зөөгч, буудлын ажилчид ба тодорхой ажил эрхэлдэггүй иргэд.

## **Зургаа. Ажлын хэсгийн ажил үүргийн хуваарь:**

### **1. Удирдлага арга зүйгээр хангах баг**

- Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах төсвийг хуваарилах
- Хамтран ажиллах байгууллага, аж, ахуйн нэгжүүдийн уялдаа холбоог хангах, үүрэгжүүлэх, ажлыг хуваарилах
- Мэдээ, тайлан хүлээн авч нэгтгэх, үр дүнг танилцуулах
- Үйл ажиллагааг дэмжих, өвчлөлийн мэдээ, тайлан, судалгааны дүнг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь илгээх, орон нутгийн удирдлагуудад мэдээллийг хүргэж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Санхүүгийн тайлан, эм, оношлуурын зарцуулалтад хяналт тавих
- Олон нийтийн оролцоог хангахад чиглэгдсэн зар мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллээр өгөх

### **2. Оношилгоо, эмчилгээ хийх баг**

- Зорилтот бүлгийн хүн амын дунд үзлэг шинжилгээг зохион байгуулах
- Лабораторийн шинжилгээг хурдавчилсан тестээр тухайн газарт хийх, шаардлагатай тохиолдолд сорьц цуглуулан, лабораторид шинжилгээ хийх
- Мэдээллийн нууцлалыг хадгалах
- Илэрсэн өвчлөлийг хяналтад авах, эмчлэх арга хэмжээг зохион байгуулах
- Үзлэгийн тайлан мэдээг ЭМС-ын 611 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу цаг хугацаанд нь мэдээлэх
- Эм, оношлуурын зарцуулалтын тайланг үнэн зөв гаргаж, тайлagnah

### **3. Хяналт үнэлгээ хийх баг**

- Санхүүгийн мэдээ тайланд хяналт тавих
- Үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, бодлого арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх
- Эм материал, оношлуурын зарцуулалтад хяналт тавих

### **Долоо. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1. Зорилтот бүлгийн хүн амын дунд БЗДХ/ХДХВ/ДОХ-ыг эрт илрүүлэг, үзлэг оношилгооны ажлыг зохион байгуулах
2. Бэлгийн замаар дамжих халдвартын өвчлөл илэрсэн иргэдийг диспансерийн идэвхтэй хяналтад авч эмчлэх

### **Найм. Хүрэх үр дүн**

1. Зорилтот бүлгийн хүн амын дундах өвчлөлийг эрт илрүүлсэн байна
2. Өвчлөл илэрсэн иргэдийг эмчилж, диспансерийн идэвхтэй хяналтад хамруулсан байна.
3. Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилсэн байна.

**Ес. Ажлын төлөвлөгөө**

Зорилтот бүлгийн хүн амын дунд БЗДХ-ын шинжилгээг зохион байгуулах хуваарь				
ӨЭМТ-үүдэд хийгдэх үзлэгийн хуваарь				
ӨЭМТ	Харьялагдах баг	Хамрагдах хүний тоо	Хариуцах эзэн	Хугацаа
Мөнхийн Гэгээ ӨЭМТ	Рашаант Шанд Даваат	340	Г.Мядагханд – ӨЭМТ-ийн дарга	10 сарын 07-16
Учралтбаяр ӨЭМТ	Дэнж Эрдэнэ	275	Д.Нарангэрэл - ӨЭМТ-ийн дарга	
Энхжихмандариваа ӨЭМТ	Шанд Их залуу Яргуйт	131	Г.Эрдэнэтүяа - ӨЭМТ-ийн дарга	
Үйлсбадрах ӨЭМТ	Цагаанчuluут Наран Рашаант Уртын гол	627	С.Мандах - ӨЭМТ-ийн дарга	
Нийцэл ӨЭМТ	Булаг Цагаанчuluут Баянбулаг	167	Г.Болормаа - ӨЭМТ-ийн дарга	
Анхны-Оч ӨЭМТ	Зэст Хүрэнбулаг Бүрэнбүст Уртбулаг	400	М.Дулмаа - ӨЭМТ-ийн дарга	
Мэндцэцэн ӨЭМТ	Оюут Уурхайчин Согоот	562	Д.Оюунсайхан - ӨЭМТ-ийн дарга	
Мөнхсүндрэл ӨЭМТ	Баянцагаан Говил	337	Б.Жаргалсайхан - ӨЭМТ-ийн дарга	
<b>Нийт</b>	<b>22 баг</b>	<b>2839</b>		